



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/17

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (COVID-19) цартахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажиглах, тандалт судалгаа хийх, тусгаарлах, дамжин өнгөрөх зорчигчдыг бүртгэх ажлын хүрээнд хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдлын нөөцийг нэмж бүрдүүлэх зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 28,800,000 (хорин найман сая найман зуун мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (И.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Бэлэн байдлын нөөц бүрдүүлэх хамгаалах хэрэгсэл, амны хаалт худалдан авах ажиллагааны талаар байгууллага, аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч худалдан авалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100041

Аймгийн Засаг даргын 2021 оны 01  
дугаар сарын 01-ны өдрийн 01/17 дүгээр  
захирамжийн хавсралт



### ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЛИЙН ТООЦОО

Д/д	Хамгаалах хувцас хэрэгслийн нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	Нэг удаагийн халад	ширхэг	1800	5000	9000.000
2	Нэг удаагийн улавч	ширхэг	1000	300	300.000
3	Нэг удаагийн үзлэгийн бээлий	ширхэг	5000	700	3500.000
4	Нүүрний хамгаалалт	ширхэг	500	2000	1000.000
5	Амны хаалт	ширхэг	100000	150	15,000,000
<b>Дүн</b>			<b>108300</b>	<b>8150</b>	<b>28,800,000</b>